



ТӨРИЙН ОРОН СУУЦНЫ КОРПОРАЦИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 11 сарын 21 өдөр

Дугаар 15

Улаанбаатар хот

“Эрдэнэт төгөл” ХХК-иас борлуулалтын авлагын
дүнд үйлчилгээний зориулалттай үл хөдлөх хөрөнгө
тооцуулан авахыг дэмжих тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.15, 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, “Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.4.16, 9 дүгээр зүйлийн 9.3.15 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Эрдэнэт төгөл” ХХК-тай 2016 оны 08 дугаар сарын 11-ний өдөр байгуулсан 2016/1-53 дугаартай захиалан бариулах гэрээний дагуу худалдан борлуулсан “Буянт-Ухаа 2” хорооллын 193 дугаартай 272 м.кв талбай бүхий үйлчилгээний төвийн барилгын суурийн борлуулалтын үлдэгдэл төлбөр болох 256,500,000 төгрөгийн авлагын дүнд дээрх үйлчилгээний төвийн 3 давхрын 74 м.кв талбайг 1 м.кв-ын үнийг 3,500,000 /гурван сая таван зуун мянган/ төгрөгөөр тооцож шилжүүлэн авах асуудлыг хэлэлцээд, Төлөөлөн удирдах зөвлөлөөс хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэхээр гаргасан саналыг дэмжсүгэй.

2. Үйлчилгээний зориулалттай үл хөдлөх хөрөнгө шилжүүлэн авах саналыг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хүргүүлэн, шийдвэрлүүлэхийг Гүйцэтгэх захирал /Б.Эрдэнэбулган/-д үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга /Ц.Шинэхүү/-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Ц.ШИНЭХҮҮ